

Аудитын код: САГ-2018/101/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа
Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитор Б.Уянга
Утас: 261628 Цахим хаяг: uyangab@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн:
“Ньюбаланс Аудит” ХХК
Утас: 70145542 Цахим хаяг: newbalance_audit@yahoo.com

Улаанбаатар хот



Агуулга

1	Аудитын гэрчилгээ	0
2	Аудитын тайлан	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	2
2.5	Дотоод хяналт.....	3
2.6	Орлого, зардал, төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	3
2.7	Шилэн дансны мэдээлэл	3
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	3
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	4
2.9.1	Авлагын бүртгэлийн талаар.....	4
2.9.2	Өглөгийн бүртгэлийн талаар	4
2.9.3	Үндсэн хөрөнгийн бүртгэлийн талаар	4
2.9.4	Биет бус хөрөнгийн бүртгэлийн талаар	5
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	5
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	5
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	5
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	5
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	5
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	5
3	Менежментийн захидал	7
3.1	Авлагын бүртгэлийн талаар.....	8
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	9
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	9
4.2	Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	11
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	12
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	13
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

“ЗАСГИЙН ГАЗРЫН АВТО БААЗ”
УТҮГ-ЫН ЗАХИРАЛ С.ЭНХБАЯР
ТАНАА

2018.03.14 № 06/675
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Засгийн газрын авто бааз” УТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Засгийн газрын авто бааз” УТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Засгийн газрын авто бааз” УТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2018\03\14SAG14.Docx

070947

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**


Үүрэг, хариуцлага

Байгууллагын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг “Засгийн газрын авто бааз” УТҮГ-ын захирал С.Энхбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, барагдуулах, биет болон биет бус хөрөнгийн бүртгэлд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн болон бусад эрх зүйн шийдвэрийн холбогдох заалт, бүртгэлийн суурийг тогтвортой мөрдөх тухай зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг хэрэгжүүлж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Засгийн газрын авто бааз” УТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.


Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Засгийн газрын авто бааз” УТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 15-наас 2018 оны 3 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 15-нд эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын



газартай байгуулсан гэрээний дагуу “Ньюбаланс Аудит” ХХК-ийн аудитор Б.Лхагвадорж, аудиторын туслах Б.Гэрэлмаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Аудитаар 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг “Засгийн газрын авто бааз” УТҮГ-ын 2018 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 1/23 дугаар албан бичгээр “Ньюбаланс Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин

“Засгийн газрын авто бааз” УТҮГ санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”, 2012 оны 77 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Анх 1935 онд Засгийн газрын авто бааз 8 автомашинтайгаар төр засгийн байгууллагуудад авто тээврийн үйлчилгээ үзүүлэх үндсэн үүрэгтэйгээр байгуулагджээ. Энэ үеэс эхлэн Монгол Улсын төр, засгийн үйл ажиллагааг хэвийн явуулахад авто тээврийн үйлчилгээгээр түргэн шуурхай, соёлтой, найдвартай ажиллагаагаар ханган ажиллаж ирсэн байна. Өдгөө “Засгийн газрын авто бааз” УТҮГ нь 210 ажиллагсадтай, 134 хөдлөх бүрэлдэхүүнтэй, жилдээ 2.5 сая километрийн ажил үйлчилгээ гүйцэтгэдэг байна.

“Засгийн газрын авто бааз” УТҮГ нь дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулан “Олон улсын стандартын түвшинд хүрсэн тээврийн нийтлэг үйлчилгээ үзүүлж, хуулиар тогтоосон зорилт, чиг үүргээ хэрэгжүүлэх таатай орчин нөхцөл бүрдүүлэх” зорилготойгоор үйл ажиллагаагаа Засгийн газрын бодлого шийдвэрт нийцүүлэн ажиллаж байна.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн


Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 - 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар “Засгийн газрын авто бааз” УТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлангийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 8 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 17 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

“Засгийн газрын авто бааз” УТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн САГ-2018/101/СТА-ТӨҮГ



технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

“Засгийн газрын авто бааз” УТҮГ нь Ритус компанийн санхүүгийн бүртгэлийн “Ноён”, тээврийн үйлчилгээний хяналтын “Авто” програмуудыг 2010 оноос хойш нэвтрүүлэн ашиглаж байна. Програмын шинэчлэл тухай бүр хийгдэж, бүртгэл тооцоо, мэдээллийг хоцрогдол, алдаагүй боловсруулж байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Засгийн газрын авто бааз” УТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн гэж үзлээ.

2.6 Орлого, зардал, төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар батлагдсаны дагуу “Засгийн газрын авто бааз” УТҮГ төсвөөс урсгал зардалд 2,391.7 сая төгрөгийн санхүүжилт авахаас бүрэн авч зарцуулсан байна.

Мөн үндсэн үйл ажиллагаанаас 1,492.1 сая төгрөг, туслах үйлчилгээнээс 1,165.8 сая төгрөгийн орлоготой ажиллажээ.

Улсын төсвөөс авсан санхүүжилтээс төлөвлөсний дагуу ажиллагсдын цалинд 2,097.9 сая, НДШ-ийн зардалд 230.8 сая, нэг удаагийн тэтгэмж, урамшуулалд 63.0 сая, нийт 2,391.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн үйл ажиллагааны бусад зардалд 2,480.5 сая, үйл ажиллагааны бус зардалд 162.9 сая, нийт 2,643.4 сая төгрөгийг зарцуулан орлогын татварын зардалд 13.4 сая төгрөгийг тооцож, 1.1 сая төгрөгийн цэвэр үр дүнтэй ажилласан байна.


2.7 Шилэн дансны мэдээлэл

“Засгийн газрын авто бааз” УТҮГ нь Шилэн дансны тухай хуульд заасны дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр мэдээллийг оруулсан байна. Байгууллагын www.baaz.cabinet.gov.mn цахим санд шилэн дансны цэсийг холбоогүй боловч шилэн дансны www.shilendans.gov.mn цахим санд байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан зарлагын гүйлгээ, нийлүүлэгчийн нэр, хаяг зэрэг мэдээллийг оруулжээ. Тайлант онд Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитад хамрагдаж хангалттай үнэлгээ авсан байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 8 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 17 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн төрийн аудитын байгууллага” тус бүрээр баримтжуулах гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.



Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Авлагын бүртгэлийн талаар

Санхүүгийн тайлангаарх авлагын үлдэгдлээс 18.7 сая төгрөгийн авлагыг харилцагч байгууллагатай тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант хугацааны эцэс дэх авлагын үлдэгдлийг харилцагч байгууллагатай бүрэн тооцоо нийлж баталгаажуулах, авлага барагдуулж ажиллах талаар зөвлөмж өгөх;

2.9.2 Өглөгийн бүртгэлийн талаар

Шатахууны картын урамшуулал 3.8 сая төгрөгийг өглөгөөр бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дугаар хавсралтаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 2.4-т “Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа бүтээгдэхүүнийг орлого гэж хүлээн зөшөөрнө” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

2.9.3 Үндсэн хөрөнгийн бүртгэлийн талаар

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 112 дугаар тогтоолоор балансаас балансад шилжиж ирсэн “Lexus 570” маркийн “01-25 УНУ” дугаартай автомашиныг тухайн үед нь буюу 2016 оны санхүүгийн тайланд үнэн зөв бүртгэсэн боловч 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн залруулах бичилтээр уг автомашины 126.8 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг дахин үүсгэж, борлуулалтын өртөгт бүртгэсэн нь тайлант хугацааны санхүүгийн үр дүнг материаллаг хэмжээний нөлөө үзүүлсэн байна.
- Тээврийн хэрэгслийн дансанд бүртгэлтэй 134 ширхэг автомашины 2017 оны 9 дүгээр сард тооцогдох 66.7 сая төгрөгийн элэгдлийг тооцолгүй орхигдуулсан байна.
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 468 дугаар тогтоолын дагуу “Увс АЗЗА” ТӨХК-д балансаас балансад шилжүүлсэн 69.3 сая төгрөгийн үлдэх өртөгтэй “Ланд крузейр-200” маркийн “07-39 УНУ” дугаартай автомашиныг тайлант оны үндсэн хөрөнгийн бүртгэлээс хасалт хийгээгүй байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө”, 3 дугаар зүйлийн 3.1.1-д “нягтлан бодох бүртгэлийн аккрузал суурь” гэж мөнгө хүлээн авсан, эсхүл төлсөн эсэхээс хамаарахгүйгээр орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 262.8 сая төгрөгийн алдааг залруулсан.



2.9.4 Биет бус хөрөнгийн бүртгэлийн талаар

Тус байгууллага биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 3.5 сая төгрөгийн анхны өртөгтэй клип, баримтат киноны 2017 оны хорогдуулалт 0.7 сая төгрөгийг дутуу тооцсон байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын “Биет бус хөрөнгө” хэсэгт “Санхүүгийн байдлын тайланд биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдол, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дансны цэвэр дүнгээр нь толилуулна” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

“Засгийн газрын авто бааз” УТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар авлага барагдуулалт болон автомашины шилжилт хөдөлгөөнтэй холбоотой үндсэн хөрөнгийн гүйлгээг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

“Засгийн газрын авто бааз” УТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 286.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба аудитын явцад 267.3 сая төгрөгийн бүртгэлийн алдааг залруулж, санхүүгийн тайланг өөрчлөн бэлтгүүлсэн бөгөөд авлагын үлдэгдлийг баталгаажуулах, барагдуулах талаар 18.7 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

“Засгийн газрын авто бааз” УТҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар авлага барагдуулах талаар зөвлөмж өгснөөс 85.6 сая төгрөгийн авлагыг барагдуулж, зөвлөмжийн биелэлт 50.0 хувьтай байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:


Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгов.

“Засгийн газрын авто бааз” УТҮГ-ын 2017 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 5,049.6 сая төгрөг бөгөөд түүний 2.0 хувиар буюу 101.0 сая төгрөгөөр материаллаг байдлын түвшинг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид “Засгийн газрын авто бааз” УТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Засгийн газрын авто бааз” УТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлд ийм олон гүйлгээний болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС-тунд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд



алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь “Засгийн газрын авто бааз” УТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 Авлагын бүртгэлийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Санхүүгийн тайлангаарх авлагын үлдэгдлээс 18.7 сая төгрөгийн авлагыг харилцагч байгууллагатай тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн хуулийн заалт зөрчигдөх, санхүүгийн тайлангийн “үнэн зөв”, “эрх үүрэг” батламж мэдэгдлүүд хангагдахгүй байх;

ҮАГ-ын зөвлөмж

Тайлант хугацааны эцэс дэх авлагын үлдэгдлийг харилцагч байгууллагатай бүрэн тооцоо нийлж баталгаажуулах, авлага барагдуулж ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгч байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж зөвшөөрүүлсэн болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА


**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	398,453,165.91	707,962,489.00
Дансны авлага	76,544,720.10	42,515,069.50
Ажилчдаас авах авлага	16,668,738.32	1,091,647.05
Бусад авлага	196,937,295.00	327,484,811.00
Бусад санхүүгийн хөрөнгө		
Бараа материал	69,811,384.75	82,793,378.06
Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
Бусад эргэлтийн хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгийн дүн	758,415,304.08	1,161,847,394.61
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	11,236,519,067.39	10,863,516,662.22
Биет бус хөрөнгө	1,737,499.96	579,166.62
Биологийн хөрөнгө		
Урт хугацаат хөрөнгө оруулалт		
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
Хойшлогдсон татварын хөрөнгө		
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
Бусад эргэлтийн бус хөрөнгө		
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	11,238,256,567.35	10,864,095,828.84
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	11,996,671,871.43	12,025,943,223.45
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	1,645,932.00	27,442,770.00
Цалингийн өглөг		
Татварын өр	4,006,847.36	25,119,790.92
ЭМД-ийн өглөг		
Бусад өглөг		
Хүүний өглөг		
Урьдчилж орсон орлого	16,917,574.86	1,854,400.00
Нөөц /өр төлбөр/		
Бусад богино хугацаат өр төлбөр	3,683,720.00	
Богино хугацаат өр төлбөрийн дүн	26,254,074.22	54,416,960.92
Бусад урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл		
Урт хугацаат өр төлбөрийн дүн		
Өр төлбөрийн нийт дүн	26,254,074.22	54,416,960.92



Эздийн өмч		
Өмч:- төрийн	11,744,520,814.45	11,744,520,814.45
- хувийн		
Халаасны хувьцаа		
Нэмж төлөгдсөн капитал		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
Эзэмшигчдын өмчийн бусад хэсэг		
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	225,896,982.76	227,005,448.08
Эздийн өмчийн дүн	11,970,417,797.21	11,971,526,262.53
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	11,996,671,871.43	12,025,943,223.45



4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
Борлуулалтын орлого	1,328,816,143.98	1,492,075,998.22
Борлуулалтын өртөг	2,096,225,800.55	1,919,288,979.65
Нийт ашиг (алдагдал)	(767,409,656.57)	(427,212,981.43)
Түрээсийн орлого		
Хүүний орлого		
Ногдол ашгийн орлого		
Татаас санхүүжилтын орлого	1,668,547,100.00	2,391,689,700.00
Бусад орлого	1,718,301,822.27	1,165,813,846.40
Борлуулалт маркетингийн зардал	1,248,440,760.68	2,839,146,452.24
Ерөнхий ба удирдлагын зардал	1,266,309,808.28	87,582,366.00
Санхүүгийн зардал		
Бусад зардал		
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	753,826.17	(95,169.93)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	248,275,000.00	(69,277,572.00)
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
Бусад ашиг (алдагдал)	(338,523,670.29)	(119,661,639.00)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	15,193,852.62	14,527,365.80
Орлогын татварын зардал	8,137,227.10	13,418,900.48
Татварын дараах ашиг (алдагдал)	7,056,625.52	1,108,465.32
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	7,056,625.52	1,108,465.32
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
Бусад олз (гарз)	-	-
Орлогын нийт дүн	7,056,625.52	1,108,465.32
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		



4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	НИЙТ ДҮН
2016оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	11,744,520,814.45	218,840,357.24	11,963,361,171.69
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт			
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			
Тайлант үеийн үр дүн		7,056,625.52	7,056,625.52
2016оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,744,520,814.45	225,896,982.76	11,970,417,797.21
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт			
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			
Тайлант үеийн үр дүн		1,108,465.32	1,108,465.32
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,744,520,814.45	227,005,448.08	11,971,526,262.53



4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮНДСЭН АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн (+)	3,523,186,122.72	4,071,508,666.47
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,285,868,506.75	1,219,521,809.76
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Татаас санхүүжилтийн орлого	1,668,547,100.00	2,391,689,700.00
Бусад мөнгөн орлого	568,770,515.97	460,297,156.71
Мөнгөн зарлагын дүн (-)	3,155,321,268.11	3,574,688,413.38
Ажиллагчдад төлсөн	1,315,777,074.00	1,629,605,091.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	374,216,964.00	443,564,892.00
Бараа материал худалдан авахад төлсөн	9,005,738.00	12,399,298.00
Ашиглалтын зардалд төлсөн	172,809,306.00	186,673,644.37
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	719,359,730.00	774,610,020.00
Татварын байгууллагад төлсөн	153,369,472.26	187,531,488.24
Даатгалын төлбөрт төлсөн		54,000.00
Бусад мөнгөн зарлага	410,782,983.85	340,249,979.77
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	367,864,854.61	496,820,253.09
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн (+)	250,025,000.00	-
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	250,025,000.00	
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
Хүлээн авсан хүүний орлого		
Хүлээн авсан ногдол ашиг		
Улсын төсвийн хөрөнгө оруулалт		
Мөнгөн зарлагын дүн (-)	425,018,090.00	187,310,930.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн өөрийн хөрөнгө	425,018,090.00	187,310,930.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(174,993,090.00)	(187,310,930.00)
САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн (+)	1,025,838.59	-
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Төрөл бүрийн хандив		
Бусад орлого	1,025,838.59	
Мөнгөн зарлагын дүн (-)	272,012.42	-
Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн		
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		

ӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ЗӨРЧИЛГҮЙ -
 САНАЛ ДҮГНЭЛТ

Төлсөн ногдол ашиг		
Бусад зарлага	272,012.42	
САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	753,826.17	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	193,625,590.78	309,509,323.09
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	204,827,575.13	398,453,165.91
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	398,453,165.91	707,962,489.00



4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/ Зөрүү
НИЙТ ЗАРДАЛ ДҮН	2,391,689,700	2,391,689,700	
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,391,689,700	2,391,689,700	-
Бараа үйлчилгээний зардал	2,328,689,700	2,328,689,700	-
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	2,097,918,700	2,097,918,700	-
Үндсэн цалин	1,900,897,800	1,900,897,800	-
Гэрээт ажилчдын цалин	15,898,400	15,898,400	-
Унаа хоолны хөнгөлөлт	181,122,500	181,122,500	-
Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл	230,771,000	230,771,000	-
Тэтгэврийн даатгал	146,854,200	146,854,200	-
Тэтгэмжийн даатгал	20,979,100	20,979,100	-
ҮОМШ өвчний даатгал	16,783,400	16,783,400	-
Ажилгүйдлын даатгал	4,195,900	4,195,900	-
Эрүүл мэндийн даатгалын хураамж	41,958,400	41,958,400	-
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	63,000,000	63,000,000	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,391,689,700	2,391,689,700	-
Улсын төсвөөс санхүүжих	2,391,689,700	2,391,689,700	-
Төсвийн бусад мэдээллийн ангилал			-
Байгууллагын тоо	1	1	-
Ажиллагсадын тоо	210	210	-
Удирдах ажилтан	3	3	-
Гүйцэтгэх ажилтан	207	207	-
Үйлчдэх ажилтан	-	-	-
Гэрээт ажилтан	-	-	-

